



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/236

Чингис хот

Бэлчээрийн менежментийн ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 29.1.3-ын "а", Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал аж ахуйн бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийн үр өгөөжтэй тогтолцоо, бэлчээрийн тогтвортой менежментийг бүрдүүлэхэд хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Аймгийн Засаг орлогч

Нарийн бичгийн  
дарга:

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот  
байгуулалтын газрын дарга

Аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн дарга

Аймгийн Байгаль орчин, аялал, жуулчлалын  
газрын дарга

Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний албаны  
дарга

Аймгийн Бэлчээр ашиглалтын холбооны тэргүүн

Мал эмнэлгийн газрын дарга

Олон улсын төсөл хөтөлбөрийн төлөөлөл

Сумдын Засаг дарга нар

2. Аймгийн хэмжээнд бэлчээр ашиглалтын журам, бэлчээр ашиглалтын төлөвлөлгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх, мал аж ахуйн эрсдлийн санг бий болгон хөгжүүлэх ажлыг зохион байгуулж явц, үр дүнг цаг тухайд нь аймгийн Засаг даргад танилцуулж байхыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

331010642

2.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/205 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА